

ЭЛСЭЛТ 2018

Хаяг:

Удирдлагын академи
Улаанбаатар хот, 17012
Хан-Уул дүүрэг
11 дүгээр хороо
Удирдлагын академийн гудамж-1

Утас:

Магистрын сургалт: 70132272
Мэргэшүүлэх дипломын сургалт:
70132094

Веб хуудас:

www.naog.gov.mn

Элсэлтийн бүртгэл

2018 оны 10 дугаар сарын 01-12-ны ажлын өдрүүдэд Аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд явагдана.

1. УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Удирдлагын академийн үндэс суурь 1914 онд тавигдсан бөгөөд 1941 оноос дээд боловсролтой удирдах ажилтныг сургаж бэлтгэх болсон. 1994 онд УИХ, Засгийн газрын шийдвэрээр Удирдлагын хөгжлийн институт, Төр, нийгмийн судлалын академи, Төрийн бодлого, нийгмийн асуудал судлах төв гэсэн төр, засгийн харъяаны сургалт, эрдэм шинжилгээний гурван байгууллагыг өөрчлөн зохион байгуулж Засгийн газрын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага болох Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийг байгуулсан бөгөөд 1999 онд Удирдлагын академи болгон өөрчилсөн юм.

АЛСЫН ХАРАА

Удирдахуйн сургалт, судалгааны үндэсний тэргүүлэх байгууллага байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Манлайлан ажиллах төгсөгч, мэдлэг тэлэх судалгаа, хөгжилд хөтлөх зөвлөгөөг бид бүтээнэ.

ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

- ❖ Үндэсний бахархал, үнэт зүйлс, эрх ашиг, эв нэгдэл
- ❖ Үйл ажиллагааны шинжлэх ухаанч чанар
- ❖ Ёс суртахуунч чанар
- ❖ Сэтгэл, зүтгэл, гүйцэтгэлийг эрхэмлэх

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

- Төр, нийгэм, бизнесийн салбарын удирдах ажилтныг сургаж бэлтгэх
- Төр, нийгэм, бизнесийн салбарын удирдлагын асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх
- Төр, нийгэм, бизнесийн удирдлагын асуудлаар зөвлөгөө өгөх

2. МЭРГЭШҮҮЛЭХ ДИПЛОМЫН БОЛОН МАГИСТРЫН СУРГАЛТ

Мэргэшүүлэх дипломын сургалт

Уг сургалт нь боловсролын бакалаврын зэрэгтэй хүмүүст төрийн захиргааны менежмент, бизнес, төрийн удирдлагын чиглэлээр мэдлэг, ур чадвар олгож мэргэшүүлнэ. Дипломын сургалтад суралцагч нь тухайн мэргэшлийн хүрээнд тодорхой чиглэлээр гүнзгийрэн мэргэших ба төр, төрийн бус, бизнесийн байгууллагын дунд түвшний удирдах албан тушаалд ажиллах мэдлэг, ур чадвар эзэмшиж төгсөнө. Суралцагч нь нийт **21** багц цагийн агуулгыг судална.

Үүнд:

- Мэргэжлийн суурь хичээл – **6** багц цаг
- Мэргэшүүлэх хичээл – **10** багц цаг
- Мэргэшүүлэх сонгон судлах хичээл – **4** багц цаг
- Төгсөлтийн шалгалт – **1** багц цаг

Магистрын зэрэг олгох сургалт

Магистрын сургалт нь боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй хүмүүсийг төрийн захиргааны менежмент, төрийн удирдлага, бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэшүүлэн сургаж удирдах албан тушаал эрхлэхэд шаардагдах мэдлэг чадвар эзэмшүүлнэ. Магистрын сургалтад суралцагч нь тухайн мэргэшлийн хүрээнд тодорхой чиглэлээр гүнзгийрэн мэргэших бөгөөд бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа хийх мэдлэг, арга зүй эзэмшинэ. Суралцагч нь нийт **36** багц цагийн (үүнээс 20 багц цагийг мэргэшүүлэх дипломын сургалтаар судалсан байна) агуулгыг судална. Үүнд:

- Ерөнхий суурь хичээл – **4** багц цаг
- Мэргэжлийн суурь хичээл – **6** багц цаг
- Мэргэшүүлэх хичээл – **10** багц цаг
- Мэргэшүүлэх сонгон судлах хичээл – **8** багц цаг
- Магистрын судалгааны ажил – **8** багц цаг

Сургалтын хугацаа

Удирдлагын академид хичээлийн жил нь тус бүр **8** долоо хоног үргэлжлэх **4** улиралтай байна. Суралцах хугацаа нь сургалтын түвшин, суралцах хэлбэрээсээ хамааран ялгаатай. Үүнд:

- *Сертификатын сургалт*
 - Өдөр: 1 улирал танхимд хичээллэх 8 долоо хоног
 - Гараг: 2 улирал танхимд хичээллэх 16 долоо хоног
- *Дипломын сургалт*
 - Өдөр: 3 улирал танхимд хичээллэж төгсөх, нийт 6 сар үргэлжилнэ.
 - Гараг: 5 улирал танхимд хичээллэж төгсөх, нийт 15 сар үргэлжилнэ.
 - Улирал: 2 улирал танхимд 1 улирал зайн хэлбэрээр хичээллэж төгсөх, нийт 6 сар үргэлжилнэ.
- *Магистрын сургалт*

Академийн мэргэшүүлэх дипломын сургалтыг төгсөгч нь

 - Гарагаар суралцахад 2 улирал танхимд хичээллэж, 3 дахь улиралд магистрын судалгааны ажлаа бичиж хамгаална.
 - Улирлаар суралцахад 1 улирал танхимд хичээллэж, 2,3 дахь улиралд магистрын судалгааны ажлаа бичиж хамгаална.

3. ЭЛСҮҮЛЭХ МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ

- Төрийн захиргааны менежмент
- Бизнесийн удирдлага
- Төрийн удирдлага

4. СУРГАЛТЫН ТӨЛБӨР

Мэргэшүүлэх дипломын сургалтын “Улирал”-ын хэлбэр:

- Сургалтын нийт төлбөр **2’751’000** төгрөг.

Магистрын сургалтын “Улирал”-ын хэлбэр:

- Сургалтын нийт төлбөр **3’824’000** төгрөг.

5. ЭЛСЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

Мэргэшүүлэх дипломын сургалт:

- Боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх.

Магистрын сургалт:

- Боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байх
- Удирдлагын академийн мэргэшүүлэх дипломын сургалтыг 2010 оноос хойш амжилттай (голч дүн 3.0-с дээш) дүүргэсэн байх.

Бүртгүүлэхэд шаардлагатай материал:

- Иргэний үнэмлэх (эх хувь)
- Бакалаврын зэргийн диплом (эх хувь)
- Магистрын сургалтад элсэгч нь Академиас тогтоосон элсэгчийн анкет, судалгааны санал зэрэг холбогдох материалыг бүрдүүлсэн байна.
- Бүртгэлийн хураамж—
 - Мэргэшүүлэх дипломын сургалт 20’000 төгрөг
 - Магистрын сургалт 25’000 төгрөг

6. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ, ШАЛГАРУУЛАЛТ

Мэргэшүүлэх дипломын сургалт:

Элсэлтийн шалгалт сорилын хэлбэрээр тухайн аймгийн ЗДТГ-т явагдана.

**2018.10.13, Бямба гараг
09:00 цагт**

Төрийн захиргааны менежмент, Төрийн удирдлага

- Төрийн удирдлага, эрх зүйн мэдлэг
- Ерөнхий мэдлэг

Бизнесийн удирдлага

- Эдийн засгийн мэдлэг
- Ерөнхий мэдлэг

Магистрын сургалт:

- Элсэгчийн анкет, судалгааны санал, холбогдох бусад материалыг Академийн элсэлтийн комисс хүлээн авч шалгаруулна.
- Элсэлтийн материалыг хүлээж авах сүүлийн хугацаа:

**2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн
18:00 цаг**